

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 9 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 9 дүгээр сард Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 610 болж, 2015 оны мөн үеэс 532 хүнээр, өмнөх сарынхаас 285 хүнээр тус тус буурчээ.

Ажилгүйчүүдийн 47.54 хувь буюу 290 нь эмэгтэйчүүд байна. 2016 оны эхнээс 484 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 395 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 33.92 хувь буюу 134 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1


Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 9 дүгээр сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр



Тайлант сард бүртгүүлсэн 145 ажилгүй иргэний 37.93 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 12.41 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 8.28 хувь нь орон тооны цомхтголоор; 7.59 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 6.21 хувь нь шилжин суурьшсан; 5.52 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 4.14 хувь нь байгууллага татан буугдсан; 3.45 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 1.38 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0.69 хувь нь цэргээс

халагдсан; 0.69 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 11.72 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.
Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 9 дүгээр сарын эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 9 сард НДШ-ийн орлого 12.1 тэрбум ₮ болж төлөвлөгөө 98.71 хувь болж, төлөвлөгөөг 11 сум 2.65-30.1 хувиар давуулан биелүүлж. Архуст, Аргалант, Алтанбулаг, Баян, Баянхангай, Бүрэн, Батсүмбэр, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Заамар, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ, Цээл, Зуунмод сумд 0.02-20.98 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 823.0 сая ₮ болж төлөвлөгөө 95.88 хувь болж, төлөвлөгөөг Зуунмод сум 24.44 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 30.1 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг

тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 271440 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 35.41 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 25.83%; тэтгэмжийн даатгалын сангийн 66.66%; эрүүл мэндийн даатгалын сангийн 91.79%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 72.50%; ажилгүйдлийн даатгалын сангийн 76.95%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 9 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 54655 хүнд олгож, 9.2 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 6.7 хувь 3432 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 17.9 хувь 1.4 тэрбум ₮-өөр тус бүр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 111140 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 42.39 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 22.99 хувийг халамжийн тэтгэвэр; 8.19 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 4.75 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 4.29 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 4.71 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.73 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




I.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 9 сард 12297 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.43 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 9 сард 928 хүүхэд мэндэллээ.

Зураг I.3

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар




Аймгийн хэмжээнд он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 15 хүүхдээр өслөө.

Зураг I.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн

9 дүгээр сарын байдлаар




2016 оны эхний 9 сард халдварт өвчнөөр 971 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1,78 хувь буюу 17 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс заг хүйтэн 80 хувь, тэмбүү 59,22 хувь, трихомениаз 44,74 хувь, вируст хепатит 25 хувь, улаан бурхан 10,22 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 107 байгаа бол: Зуунмод 287, Баян-

Өнжүүлд 176, Баян 158, Архуст 142, Угтаал 109, Сүмбэр 106 ногдлоо

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар



I.4 Байгаль орчин

Төв аймгийн нутгаар. Агаарын температурын сарын дундаж нь уулархаг нутгаар 0-5 градус хүйтэн, бусад нутгаар 0-5 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Дулаарах үе: Нэгдүгээр арав хоногийн эхээр уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус дулаан, голын ай саваар шөнөдөө 0-5 градус, өдөртөө 15-20 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүйтэн, өдөртөө 11-16 градус дулаан байна.

Бага зэрэг хүйтрэх үе: Нэгдүгээр арав хоногийн дунд үеэс уулархаг нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна.

Хүйтрэх үе: Гуравдугаар арав хоногийн дунд үеэс хүйтэрч, уулархаг нутгаар шөнөдөө 15-20 градус, өдөртөө 3-8 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтээс 3 градус дулаан байна.

Энэ сард ихэнх нутгаар 6,0-11,5 мм, Баян, Баянцагаан сумдын нутгаар 0,6-6,0 мм буюу дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар цас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн эхэн болон эцсээр нийт нутгаар цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар 12-14 м/с, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

10 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, Монгол Алтайн уулархаг нутаг, Алтайн нурууны өмнөд хэсэг болон зүүн өмнөд говиор дунджаас дулаан, харин хур тунадас ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, Хөвсгөл, Булган, Арханай, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Дорноговийн зарим нутгаар дунджаас ахиу орохоор байна.

Хур тунадас ахиу орох нутгуудаар цас хайлмагтан мөстөж мал бэлчээрлэхэд мөн халтиргаа гулгаа үүсч зам тээврийн ажилд хүндрэл үүсч болзошгүй.

2016 оны зуны улирлын цаг агаарын нөхцөл, ургамлын ургалт болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бэлчээрийн даац хүрэлцээ муу гарсан Увс, Баян-Өлгий, Ховд, Архангай, Өвөрхангай, Булган, Төв, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Дундговийн аймгуудын зарим сумдын нутгаар мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч болзошгүй байгааг холбогдох мэргэжлийн байгууллагууд одооноос анхаарч ажиллахыг зөвлөж байна.



I.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 9 сард аймгийн хэмжээнд

651 гэмт хэрэг бүртгэгдэж 626 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2925.4 сая₮-ийн хохирол учирлаа.


Гарсан гэмт хэргийн 36.09 хувь нь хулгай, 29.22 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 14.53 хувь нь бусад хэрэг, 15.16 хувь нь замын осол, 4.06 хувь нь танхай дээрэм, 0.94 хувь нь хүн амины хэрэг тус бүр эзлэв. Батсүмбэр, Заамар, Сэргэлэн, Аргалант, Борнуур, Баянжаргалан, Эрдэнэ, Жаргалант, Баяндэлгэр, Баянчандмань, Эрдэнэсант сумдад 10000 хүнд 359-77 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (70)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 47 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 35 эмэгтэй, 785 эрэгтэй нийт 820 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оны мөн үеэс 77 хүнээр буурлаа.

Зураг I.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар




Гарсан гэмт хэргийн 5.8 хувь нь бүлгээр 26.4 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 290 хүн гэмтэж 85 хүн нас барлаа.


Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар



Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 9 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 9 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 748 гүйцэтгэх хуудсанд нийт 4.12 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 13 гүйцэтгэх хуудсанд ногдох 552.3 сая ₮-ийн

материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 735 гүйцэтгэх хуудасны 3.57 тэрбум ₮-өөс 333 хуудасны 748.9 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 45.31 хувь, үнийн дүнгээр 20.99 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 6.28 нэгжээр буурч, үнийн дүнгийн биелэлт 7.42 нэгжээр тус тус буурлаа

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 9 сард кассын орлого 310.7 тэрбум ₮, кассын зарлага 312.8 тэрбум ₮ болж, гүйлгээнд 252.2 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 138341, зээлийн багцын дүн 453.7 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 50262 олгосон зээлийн дүн 83.4 тэрбум ₮ боллоо.

Иргэдийн хувийн хадгаламжинд 9 сарын 30-ний байдлаар хугацаатай хадгаламж 36.4 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 11.9 тэрбум ₮ байна.

Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 9 сарын 30-ны байдлаар 207604 иргэний 8.8 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.08-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.

Банк бус санхүүгийн байгууллага

Төв хөгжил, Түмэн мод, Сонин шийдэл кредит, Интерхэлп, Зуун дэлгэрэх, Фишин файнд банк бус санхүүгийн байгууллагууд 2016 оны эхний 9 сард 1337 зээлдэгч нарт 2364.0 сая ₮-ийн зээл олгож, 3.3 тэрбум ₮-ийн зээлийн өрийн үлдэгдэлтэй гарлаа.

Арилжааны даатгал.

Арилжааны даатгал эрхлэн явуулдаг байгууллагууд 2016 оны эхний 3-дугаар улиралд 17502 даатгуулагчийг хамруулан 653.4 сая ₮-ийн даатгалын хураамж хуримтлуулж, 89.3 сая ₮-ийн нөхөн төлбөр олгожээ.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2016 оны эхний 9 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 9.1 тэрбум ₮, зарлага 48.5 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 109.80 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; ХХОАТ, бусад орлого, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, нохойн албан татвар, бусад төлбөр, хураамжийн төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 8.1 хувь буюу 685.3 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 88.22 хувийг татварын, 11.17 хувийг татварын бус, 0.60 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 3.35 нэгжээр өсч, татварын бус орлого 2.33 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 1.01 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 16.7 тэрбум ₮ болж аймгийнх 7.3 тэрбум ₮ буюу 53.38 хувь, сумынх 1.8 тэрбум ₮ буюу 13.12 хувь, улсынх 4.6 тэрбум ₮ буюу 33.51 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 6.36 хувь буюу 36.7 сая ₮-өөр өсч 1.0 тэрбум ₮ болж, авлага 46.45 хувь буюу 65.7 сая ₮-өөр өсч 207.1 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 9.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 109.80 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.8 тэрбум

₮ болж, төлөвлөгөө 137.42 хувь биелж, Алтанбулаг, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баян, Баянжаргалан, Баянхангай, Баянцогт, Борнуур, Дэлгэрхаан, Заамар, Сүмбэр, Угтаал, Эрдэнэ, Эрдэнэсант сумд 58.27-1.18 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 7.3 тэрбум ₮ болж 104.63 хувь биелж Баян, Баянжаргалан, Баянцагаан, Баянцогт, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Угтаал, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод сумд төлөвлөгөө 36.14-4.99 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний

үнэ

2016 оны 9 дүгээр сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 64.53%, өмнөх оны мөн үеэс 3.42%-аар тус тус өсч, өмнөх сараас 0.28 хувиар буурав. ХҮИ-ийн 2016 оны 9 дүгээр сарын 0.28 хувийн бууралтад хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.32 нэгжийн буурсан нь голлон нөлөөлөв.

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ХҮИ өмнөх оны мөн үеэс 3.42% өссөний дотор хувцас бөс бараа гутлын бүлэг 6.81%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 9.11%; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 5.29%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 4.51%; тээврийн бүлэг 4.12%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 4.01%; амралт чөлөөт цаг, соёлын бараа

үйлчилгээний бүлэг 1.34%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 0.67%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.39%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.03%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 4.18%-аар буурав. Боловсролын үйлчилгээний бүлэг үнэ тогтвортой байв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 оны 9 сард	
	лунктээр	хувиар
Бүгд	-0.28	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.32	115.12%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	-1.33%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ТҮТАЛ	0.03	-10.61%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00	0.50%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.00	-1.68%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	-0.11	41.26%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	-8.53%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.10	-34.74%



II.5 Аж үйлдвэр


Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2016 оны эхний 9 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 28.79 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 11.1 хувь буюу 2.87 сая ₮-өөр өслөө.

Зураг II.6

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, оны үнээр, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015	2016	2015	2016	Дүнд эзлэх % Percentage share to total		2016/ 2015%
	IX	IX	I-IX	I-IX	2015 I-IX	2016 I-IX	
Нийт дүн	1,054.08	5,458.48	25,924.86	28,797.36	100.0	100.0	111.1%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	378.43	5,174.76	20,781.18	25,159.26	8532.61%	87.37	121.1%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	618.29	262.53	4,082.62	2767.89	10.24	9.61	67.8%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	57	21.19	1,061.06	870.21	4.4	3.02	82.0%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хувцас үйлдвэрлэл, модон эдлэл үйлдвэрлэл, ус хариутгал хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 3.6 дахинаас 0.1 хувь буюу 4.37 тэрбумаас-2.0 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Эрдэнэ, Батсүмбэр, Баян, Угтаалцайдам сумд 45.91-0.29 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 98.36) хувийг эзлэв.




II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2016 оны эхний 9 сард 3205.4 сая ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулахад 31.59 хувь буюу 1480.1 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 67.67 хувь нь орон сууцны бус барилгад; 20.16 хувь нь инженерийн барилга байгууламжид; 12.17 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2015 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 34.75 пунктээр, орон сууцны барилгын ажил 7.44 пунктээр тус тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 42.19 пунктээр буурав.

Зураг II.8

Барилга угсралт, их засварын ажил жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, тэрбум.₮




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 9 сард 134.6 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 62.0 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.96 хувь буюу 33.6 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 73.9 сая ₮ болсон ба нийт орлогын 80.1 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 19.84 хувийг албан бичгийн, 10.35 хувийг зорчигчдын, 69.81 хувийг бусад орлого бүрдүүлжээ.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр



Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 9 сард нийт 6550 иргэд, аж ахуйн нэгжийн

үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулалтыг хийж 42.4 сая ₮-ийн орлого орууллаа.

Нийт орлогын 44.6 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 36.9 хувийг зээлийн барьцаанаас, 11.8 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 4.1 хувийг худалдааны үйлчилгээнээс, 2.8 хувийг бэлэглэлээс тус бүр оруулжээ

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 9 сард нийт 995 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 21; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 462; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 17; бэлэглэлийн гэрээ 18; худалдах, худалдан авах гэрээ 56; өв залгамжлал 7; барьцааны гэрээний бүртгэл 309; бусад бүртгэл 105 тус бүр бүртгүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 9 сард нийт 103 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 62 ; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 16; шашин 3; боловсрол сургалтын байгууллага /БСБ/ 1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 6; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 4; Төсөвт 5; Хоршоо 4; бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/ 1; хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл /ХХН/ 1; орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/ 1 тус бүр бүртгүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 9 сарын мэдээгээр 168 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 46; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 22; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 8; удирдлага өөрчлөгдсөн 22; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 14; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 20; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр өөрчлөгдсөн 15;

татан буугдсан 15; тус бүр бүртгүүлээ. Мөн 45 иргэн, 14 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 9 сарын мэдээгээр нийт 260 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 491; үүнээс тохирлын гэрчилгээ 421, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 70; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 3478; үүнээс цулын хэмжүүр 642, жин 550, туухай 82, автомашины жин 10; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 345; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 214, мерник 13, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 12, сүмбэн метр 33, уртын хэмжих хэрэгсэл 13, усны тоолуур 60; нэг фазын тоолуур 2469, гурван фазын тоолуур 22, даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.

Мал эмнэлэг

Мал эмнэлгийн бүх төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2016 оны эхний 9 сард 5910.2 мянган толгой мал хамрагдсан нь 2015 оны мөн үеэс 22.4 хувь буюу 1082.8 мянган толгойгоор өслөө. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ халдварт өвчнийх 99.28 хувь, ариутгал халдваргүйтэлийнх 86.60 хувийн гүйцэтгэлтэй биелэгдэж, халдварт өвчнөөр 2288 мал хорогдлоо.

Аудит

Аймгийн аудитын газар 2016 оны эхний 9 сард 281 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 220 нь зөрчилгүй, 29 нь хязгаарлалттай, 1 нь

сөрөг дүгнэлтүүдтэй гарлаа. Аудитын үйлчилгээний төлбөр 8.1 сая ₮ оруулахаас, орон нутгийн төсөвт 8.1 сая ₮-ийг орууллаа.

Тайлангийн хугацаанд 17.9 тэрбум ₮-ийн 394 төлбөрийн акт, албан шаардлагыг тавьж 12.3 тэрбум ₮-ийг барагдуулсан нь биелэлтийн хувь тоогоор 72.34, үнийн дүнгээр 68.58 хувьтай гарлаа.

2016 оны эхний 9 сард 839 алдаа 37.3 тэрбум ₮-ийн зөрчил илрүүллээ. Үүнээс 86 алдаа 10.8 тэрбум ₮-ийг залруулсан.